

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ  
ШИЙДВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД, ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БОЛОН БУСАД  
БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ**

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц
1	2	3	4
<b>1.г.Ерөнхийлөгчийн зарлиг</b>			
1		2021.08.25 №39 “Ажлын хэсэг байгуулах тухай”	<p>Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дугаар 39 зарлигаар батлагдсан “Уур амьсгалын өөрчлөлт, түүний хор уршиг, нөлөөлөл болон цөлжилтийг бууруулах талаар санал дүгнэлт боловсруулах чиглэлд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүнээр тус газрын дарга ажиллаж байна.</p> <p><b>Хэрэгжүүлж байгаа ажлын талаарх танилцуулга</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ 2021 онд бэлчээрийн газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын аргачлалыг нэвтрүүлж, цаашид бэлчээрийн газрын төлөв байдал чанарын хянан баталгаа, мониторинг хийх дэвшилтэд аргачлал, техник технологийг ашиглах боломжийг бүрдүүлэхийг зорьж ажиллаж байна.</li> <li>✓ 2021 оны байдлаар бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн 330 сумын хэмжээнд 110°850’353 га бэлчээрийн газрын 5163 мониторингийн цэгт хийсэн байна. Судалгааны үр дүнгээр 14°937’269.56 га талбай буюу 12% нь байгалийн унаган төрхөө алдаагүй, 50°575’233.36 га талбай буюу 45% нь бага зэрэг доройтсон, 21°370’981.21 га талбай буюу 18% нь дунд зэрэг доройтсон, 158°194.62 га талбай буюу 17% нь хүчтэй доройтсон, 7°385’675.4 га талбай буюу 8% нь маш хүчтэй доройтсон байна.</li> <li>✓ 2020 онд Улсын хэмжээнд бэлчээр болон хот тосгон бусад суурин газрын мониторингийн 1000 цэгт, 2021 онд бэлчээрийн мониторингийн 500 цэгийн ерөнхий мэдээлэл ургамлын бичиглэл, мониторингийн цэгийн хянан баталгааны дүгнэлт зэрэг мэдээлэл бүхий хувийн хэрэг, хөрсний агрохими, хүнд метал, эрүүл ахуйн, дээжний мэдээ, ургамлын бичиглэлийн ажлыг хийж нэгдсэн нэг мэдээллийн санг үүсгэсэн. 1000 цэгийн байнгын ажиглалтын 941 талбарт судалгааны ажил гүйцэтгэж газрын гадарга, хөрс, ургамлан нөмрөгийн ижил хэв шинж, газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт, газар ашиглалтын онцлог, гадаргын төрх байдал, хөрсөн бүрхэвчийн төлөв байдал, доройтол, бохирдолт зэргийг тодорхойлж мэдээллийн сан бүхий сүлжээний зургуудыг үүсгэсэн.</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>✓ 2018-2020 онд нийт Монгол орны нутаг дэвсгэрийг хамарсан Газрын мониторингийн үндэсний сүлжээг байгуулж, түүнийг эрхлэх газрын мониторингийн цахим систем бүхий мэдээллийн санг үүсгээд байна. Газрын мониторингийн цахим системд газрын нэгдмэл сангийн ангиллын бүх газарт мониторингийн 12,646 /бэлчээр-8310, тариалан-2190, хадлан-258, хот суурин-1556, ой, усан сан-212, тусгай хэрэгцээ-120/ цэгийг байгуулж анхдагч мэдээллээр мэдээллийн санг үүсгээд байна.</li> <li>✓ 2019 онд газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх шаардлагатай 8 дүүргийн 97 хорооны 327393 га талбайд газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг зохион байгуулж, тус ажлын үр дүнг ашиглан шинээр газрыг олгохдоо газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг өгч байгаа бөгөөд нийслэлийн хэмжээнд газрын бохирдол, доройтолд хэсэгт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.</li> <li>✓ 2015-2021 оны хооронд “Ногоон алт” төсөлтэй хамтран “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх” ажлыг бэлчээрийн хяналт үнэлгээ хийх, төлөв байдлыг тогтоох, ургамал таних, програм хангамж ашиглах, мэдээллийн сан үүсгэх, даац ачаалал тооцох арга, аргачлалаар 21 аймгийн холбогдох мэргэжилтнүүд, 330 сумын газрын даамлуудтай хамтран нийт бэлчээрийн фотомониторингийн ажиглалт хэмжилтийн 5128 цэгт жил бүр хэмжилт судалгаа хийж мэдээллийн санд оруулан, тайлагнаж, гарсан үр дүнгээр бэлчээрийн газрын ашиглалтын нөлөөг тодорхойлон нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээг төлөвлөж дараа оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна.</li> <li>✓ Геологи хүрээлэн буй орчны суурь мэдээллийн санг 2013-2017 оны хооронд үүсгэж бусад салбарт улсын хэмжээний байгалийн шинжлэх ухааны суурь мэдээллээр хангаж ажиллаж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Уур амьсгалын мэдээлэл /агаарын даралт, агаарын температур, хур тундас, харьцангуй чийг, нарны нийлбэр цацраг/</li> <li>- Хөрс, ургамлын мэдээллийн сан</li> <li>- Геологи орчны мэдээллийн сан /геокриологи, гидрогеологи, гидрологи/</li> </ul> </li> </ul>
<b>1.е.Засгийн газрын тогтоол</b>		
1	2021.06.01 №160 “Журам батлах тухай”	Тус журмын дагуу 2022 оны Төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөллийг боловсруулан БХБЯ болон Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн уг журмыг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгох, хяналт тавих, тайлагнахад үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.
2	2021.04.28 №109 “Журам батлах тухай”	“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хүрээнд Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх зорилгоор жилд 3 хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулан нийт 80 гаруй сурвалжлага, мэдээ мэдээллийг иргэдэд фото сурвалжлага, нийтлэл, мэдээний сурвалжлага, шууд дамжуулалт хэлбэрээр нэвтрүүлсэн. Мөн

			байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр 7 хоног бүр тогтмол мэдээ, мэдээлэл иргэдэд хүргэн ажиллаж, Шилэн дансны мэдээлэлд тусгах 5 саяас дээш үнийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээ, Газрын даргын санхүүтэй холбоотой тушаал, шийдвэрийг тайлангийн хугацаанд оруулан ажиллаж байна.
3		2021.05.05 №115 “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай”	Газрын албан хаагчдыг PCR болон түргэвчилсэн шинжилгээнд тус бүр 2 удаа хамруулсан. Вакцины 1 дүгээр тунд 91 албан хаагч, вакцины 2 дугаар тунд 89, байгууллагын албан хаагчдыг Вакцины 3 дугаар тунд идэвхитэй хамрагдахыг уриалж ажилласаны үр дүнд 10-11-р сард 56 албан хаагч хамрагдаад байна. 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 05 дугаар сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд нийт албан хаагчдын 10%, 05 дугаар сарын 08-ны өдрөөс 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэл хугацаанд 30%-ийн ирцтэйгээр ажиллаж, үлдсэн 70% ийн ажилчид цахимаар ажилласан. БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаас ирүүлсэн чиглэлийн дагуу 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 8 дугаар сарын 31-ны хооронд албан хаагчдын 70 хүртэлх хувьд ээлжийн амралт олгож биеэр эдлүүлсэн. Ковид 19-өөр өвчилсөн авсан албан хаагчдын ажлын өрөөг ариутгаж, халдвар хамгаалалтын дэглэмийг мөрдүүлэн ажиллаж байна. Мөн Ковид-19 цар тахалын цаг үеийн мэдээг БХБЯ-ны шуурхай штабт өдөр бүр мэдээлж байна.
4		2021.03.24 №70 “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай”	Тус газарт хэрэгжих 2021 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ тусгагдаагүй бөгөөд урсгал төсвөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг 2021 оны 4 дүгээр сард багтаан тендер зарлаж, ажлын гүйцэтгэлийг хүлээн авч дууссан болно.
5		2021.03.24 №76 “Ажлын хэсэг байгуулах тухай”	Нийслэлийн Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэг, Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн, Баян сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх Рашаант-Мааньт чиглэлийн Богдхан төмөр замын зурвас газарт иргэн, хуулийн этгээдийн эзэмшил, өмчлөл, ашиглалтад олгосон нийт 749 нэгж талбарын 798.8 га газар өртөж байгаа бөгөөд үүнд 71 тэрбум төгрөгний нөхөн олговор олгох урьдчилсан тооцоо, судалгааг гаргаж ажлын хэсгийн хуралд танилцуулав. ЗТХЯ-наас “Богдхан төмөр замын чигийг батлуулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, БХБЯ-наас 2021 оны мн/98 тоот албан бичгээр санал авахаар ирүүлсэн. Үүний дагуу төмөр замын чигтэй давхцалтай иргэн, хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалтад байгаа нэгж талбарын судалгаа болон тогтоолын төсөлд тусгах саналыг тус газрын 2021 оны мн/121 тоот албан бичгээр БХБЯ-нд хүргүүлсэн.
6		2021.03.10 №58 “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл батлах тухай”	Тогтоолыг тогтоол шийдвэрийн бүртгэлд авч, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэлийн газрын албадад хүргүүлэн ажиллав. Сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлд хүргүүлэн Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу томилж ажиллав.

7		2021.02.21 №45 “Журам батлах тухай”	Түр журамд заасны дагуу халдварын судалгаа, өвчний мэдээлэл, эрсдэлийн үнэлгээ, тандалтын тоон мэдээнд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн халдварын тархалтын түвшинг тодорхойлж, БХБЯ-нд өдөр бүр хүргүүлэн ажиллаж байна.
8		2021.02.17 №42 “Төлөвлөгөө батлах тухай”	<p>Төлөвлөгөөний 1.3-т заасан “Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагаас иргэд, үйлчлүүлэгчдэд үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттай шилжүүлэх” ажлын хүрээнд Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийн дэд систем болох “Газрын кадастрын мэдээллийн сангийн цахим систем”-ийг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, 330 сумын Газрын даамал, нийслэл болон дүүргүүдийн Газар зохион байгуулалтын алба, Замын-Үүд, Цагааннуур, Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн алба, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай газрын захиргааны үйл ажиллагаанд тус тус нэвтрүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн Газрын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, цахим шинэчлэлийн хүрээнд Газрын даргын 2021 оны АД/2021-26 дугаар бүхий “Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийг Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /e-mongolia/-тай холбох, сервис үйлчилгээ гаргах” ажлын даалгаврыг батлуулсан ба тус ажлыг гүйцэтгэх 2021/205 тоот гэрээг Газрын даргын 2021 оны А/177 дугаар тушаалыг үндэслэн “Софт мастер” ХХК-тай 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс тус оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хугацаанд тус ажлыг гүйцэтгүүлсэн. Тус ажлын хүрээнд 15 төрлийн лавлагаа, мэдээлэл бүхий сервис үйлчилгээг бэлтгэн Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /e-mongolia/-д хүргүүлсэн.</p> <p>Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг төрийн үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia-тай холбох, сервис үйлчилгээ гаргах ажлын төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан 14 сервис үйлчилгээний сервис, загвар бэлтгэн E-Mongolia-ын хөгжүүлэгчдэд хүргүүлсэн ба тайлант хугацаанд газартай холбоотой 5 төрлийн мэдээллийг төрийн мэдээлэл, солилцооны систем ХУР байршуулж, хэрэглээнд гаргасан.</p> <p>2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Харилцаа, холбоо, мэдээлэл технологийн газарт Үндэсний дата төв болон ГЗБГЗЗГ-ын 3 талт уулзалтын хүрээнд Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-mongolia-д газартай холбоотой үйлчилгээ, лавлагаа, тодорхойлолтын мэдээллийг холбох ажлын төлөвлөгөөг боловсруулан Харилцаа холбоо мэдээлэл, технологийн газар руу 2021 оны 09 дүгээр сарын 16-ны дотор хүргүүлсэн.</p> <p>1:25000-ны масштабтай өндрийн тоон загварын хувьд 7328 ширхэг сцен байхаас нийт 88.7 GB багтаамжтай 7328 сцен мэдээллийг тус газрын ГЗЗХ-ээс хүлээн авч байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтэц /geoportal/-д оруулж бусад төрийн байгууллагуудын хэрэглээнд WMS, WFS үйлчилгээгээр ашиглах боломжийг бүрдүүлээд байна.</p> <p>Байгууллагын болон салбарын үйл ажиллагаанд ашиглагдаж буй 10 веб хуудас, системийн арчилгаа, нэмэлт хөгжүүлэлт хийж, хэвийн ажиллагааг хангаж ажиллаж байна.</p>

9		<p>2021.02.17 №43 “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”</p>	<p>Тогтоолд заасны дагуу төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг харгалзан орон тооны заасан хязгаарт багтаан, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй байх зарчмыг баримтлан ажиллаж байна. Мөн хөрөнгө бэлтгэхгүй байх, аливаа хурал, зөвлөгөөнийг цахимаар хийж, тэмдэглэлт өдөр, баяр ёслолын арга хэмжээ, уралдаан тэмцээн, аялал зугаалгыг тэмдэглэхгүй, зохион байгуулахгүй байхад анхаарч тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>
10		<p>2020.09.02 №92 “Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын чигийг батлах тухай”</p>	<p>Засгийн газрын 2020 оны 92 дугаар “Таван толгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын чигийг батлах тухай” тогтоолоор батлагдсан 207-000 дахь километрээс Монгол улсын урд хил болох төгсгөлийн цэг 30+895 километр хүртэлх төмөр замын зурвас газрыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж, тухайн зурвас газарт иргэн, хуулийн этгээдэд шинээр газар олгох боломжгүй байдлаар мэдээллийн санд хаалт хийсэн.</p>
11		<p>2020.04.29 №152 “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2020 оын 04 дүгээр сарын 02-ны өдрийн 152 дугаар тогтоолоор Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд дээрх журмыг улсын хэмжээнд үйл ажиллагаандаа мөрдөж байна. Мөн журмын өөрчлөлтийн дагуу Газрын цахим биржийн системд нэмэлт хөгжүүлэлтийг хийж үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. 2021 оны жилийн эцсийн урьдчилсан байдлаар өссөн дүнгээр нийт 2046 газрын газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан бөгөөд үүний 1877 нь цахим хэлбэрээр, 169 нь танхимаар зохион байгуулагдсан. Мөн 680 дуудлага худалдааг дахин зохион байгуулсан. Дуудлага худалдаанд нийт 1995 иргэн, хуулийн этгээд оролцож, ойролцоогоор 7.1 тэрбум төгрөгийн орлогыг Улсын төсөвт төвлөрүүлээд байна.</p>
12		<p>2020.03.25 №110 “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглэнд нэвтрүүлэх тухай”</p>	<p>Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийн дэд систем болох “Газрын кадастрын мэдээллийн сангийн цахим систем”-ийг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, 330 сумын Газрын даамал, нийслэл болон дүүргүүдийн Газар зохион байгуулалтын алба, Замын-Үүд, Цагааннуур, Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай газрын захиргааны үйл ажиллагаанд тус тус нэвтрүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн Газрын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, цахим шинэчлэлийн хүрээнд иргэн, хуулийн этгээд газрын эрхийн баримт бичиг болох газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ, нэгж талбарын кадастрын зургийг Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим систем /egazar.gov.mn/-д танилт нэвтрэлтийн “Дан” системээр нэвтэрч, системээс нууцлал бүхий QR кодоор баталгаажуулж, цахим хэлбэрээр авах, нэгж талбарын дэлгэрэнгүй мэдээллийг тодорхойлолт хэлбэрээр цахимаар авах, Монгол улсын иргэнд үнэгүй газар өмчлүүлсэн эсэх лавлагаа мэдээллийг цахимаар авах, мөн 16 төрлийн газар холбоотой хүсэлтийг цахимаар тухайн шатны Газрын албанд цахимаар гаргах</p>

			<p>боломжийг бүрдүүлж, системийн хөгжүүлэлтийг хийж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.</p> <p>Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийн дэд систем болох “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-ийг хэрэглээнд нэвтрүүлэн, аймгийн ГХБХБГ, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, сумын газрын даамал өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглан ажиллаж байна. Одоогийн байдлаар нийслэл, сум, дүүргийн 2019-2021 газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг системд бүрэн оруулж, кадастр, цахим биржийн системээр дамжуулан төлөвлөлтийн дагуу газар олгох ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2021 оны 9 сарын байдлаар системд 1700 газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн баримт бичиг цахим хэлбэрээр байршиж, хэрэгжиж байна.</p> <p>Газар зүйн нэр төрлийн 18 стандартын төслийг 2021 оны 05 дугаар сарын 11-нд зохион байгуулагдсан Газрын шинэтгэлийн үндэсний хорооны 5 дугаар хурлаар хэлэлцүүлж, хурлаас үүрэг болгосон хугацаанд батлуулах шийдвэр гарсан. Дээрх стандартын төслүүдийг батлуулах үүрэг бүхий Стандарт хэмжил зүйн газартай хамтарсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын А/110 тоот тушаалаар батлуулж, ажлын хэсгийн байгуулж стандартын төсөлд санал авсан. Энэхүү стандартад санал авахаар Стандарт хэмжил зүйн газраас 71 байгууллага руу 1/307, ГЗБГЗЗГ-аас нийт 49 байгууллагууд руу 1/1067 албан тоот бичиг тус тус хүргүүлж, нийт албан бичиг илгээсэн 120 байгууллагаас 47 байгууллага саналгүй, дэмжиж байгаа болохоо илэрхийлсэн (утсаар болон цахим шуудангаар). Нийт 26 байгууллагаас санал ирсний дагуу саналын товчоог хамаарах стандарт тус бүр дээр гаргасан. Ирүүлсэн саналын дагуу холбогдох санал, зөвлөмж, найруулга зэргийг тусгасан. Дээрх асуудлын хүрээнд ГЗБГЗЗГ-ын даргын А/110 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг дундаа цахим хэлбэрээр /googledoc/ файл нээж, түүгээр дамжуулан шүүлт хийн стандарт боловсруулагч талтай зөвшилцөн стандартын төслийг эцэслэн боловсруулсан. 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Техникийн Хороогоор хэлэлцүүлж, Стандарт хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн С/36 тоот тушаалаар батлав.</p>
13		<p>2021.10.13 №315 “Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай”</p>	<p>Засгийн газрын 2021 оны 315 дугаар тогтоолын дагуу тус газрын орлогч даргын 2021 оны А/215 дугаар тушаалаар аж ахуйн нэгжийн улсын тооллогыг салбарын хэмжээнд зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсэг 3 удаа хуралдаж, хийх ажлын төлөвлөгөөг батлан ажилласан бөгөөд салбарын хэмжээнд 373 аж ахуйн нэгжийг тоолуулах байснаас 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 372 аж ахуйн нэгж буюу 100 хувийг тооллогод хамруулсан.</p>

<b>1.ё.Ерөнхий сайдын захирамж</b>			
1		2021.06.24 №112 “Ажлын хэсэг байгуулах тухай” Эрдэнэбүрэнгийн 90 мВт-ын хүчин чадал бүхий “Усан цахилгаан станц барих төсөл”- ийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсэгт орж ажиллуулахаар Газрын даргын нэрийг тус газрын 2021 оны 05 сарын 12-ны 1/919 тоот албан бичгээр хүргүүлсэн. Ажлын хэсгийн хуралд 2 удаа оролцож, тусгай хэрэгцээний газрын гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулсан.  Нэгжийн дарга 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр тус асуудалтай холбоотой газрын давхцалын судалгаа, нөхөх олговрын талаарх нээлттэй хэвлэлийн бага хуралд оролцож, төслийн нэгжийг холбогдох мэдээллээр хангаж ажилласан.
2		2021.06.28-ны өдрийн №113 “Гашуун сухайт-Ганцмод” төмөр замын боомтын хилийн нэвтрэх хэсгийг Хятадын талтай тохиролцох ажлыг зохион байгуулах үүрэг бүхий “Ажлын хэсэг” байгуулах тухай	Монгол улсын Ерөнхий сайдын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 113 дугаар захирамжаар “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлцээр”-ийн дагуу шинээр байгуулах Гашуунсухайт-Ганцмод төмөр замын боомтын хилийн төмөр замын хил нэвтрэх цэгийг хятадын талтай тохиролцох ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.
3		2021.03.31 №85 Сансарын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн батлах тухай	Дүрмийн 3 дугаар бүлгийн 3.1.3, 3.1.4-т заасны дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд санал боловсруулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн.
<b>1.ж.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл</b>			
1		2021.07.08 Засгийн газрын Агентлагын дарга нарт /УИХ-ын 2020 оны 45, 2021 оны 10 дугаа тогтоолын хэрэгжилтийг хангуулан, салбарын хэмжээнд хэрэгжиж буй Үндэсний хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлэн, ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “ Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хугацаанд гаргах/	Газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хугацаанд холбогдох байгууллагуудад тайлагнан ажиллаж байна.

2		<p>2021.07.08 Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт /Төв аймгийн Хөшигийн хөндийн дэх шинэ хотуудын нэгдсэн төлөвлөлт /Концепци/-ийн дагуу бүсийн хөгжлийн төслийг боловсруулж, төлөвлөгөө гаргаж, арга хэмжээг авч хэрэгжүүлэх/</p>	<p>Засгийн газрын 2021 оны 38-р хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаварын дагуу Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 160 дугаар тушаал, Төв аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/422 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж, бэлтгэл ажлыг хангасан.</p> <p>Бэлтгэл ажлын хүрээнд Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт тусгай хэрэгцээнд авахаар төлөвлөж буй <b>19390.4</b> га газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж, өмчилж байгаа нийт <b>2983</b> нэгж талбарын <b>7603.7</b> га газар давхцалыг тодорхойлсон.</p> <p>Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 202/196 дугаар хамтарсан тушаалаар баталсан аргачлал, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 203 дугаар тушаалыг баримтлан давхцалтай <b>2983</b> нэгж талбараас газар дээрээ үйл ажиллагаа явуулж байгаа болон үл хөдлөх хөрөнгөтэй <b>183</b> нэгж талбарт мэргэжлийн байгууллагаар урьдчилсан үнэлгээ хийлгэхэд <b>40.532.510.036</b> төгрөгийн нөхөх олговрын тооцоо гарсан.</p> <p>Төв аймгийн Алтанбулаг сумын иргэдтэй 2021 оны 08 сарын 17-ны өдөр, Сэргэлэн сумын иргэдтэй 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдөр, 2-р багийн иргэдтэй 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдөр тус тус уулзалт хийж газрыг улсын тусгай хэрэгцээнд авах талаар танилцуулга мэдээлэл хийж, саналыг сонсох ажиллагааг зохион байгуулсан.</p> <p>Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт 19390.4 га газрыг Улсын тусгай хэрэгцээнд авах асуудлаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 06 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, газрын хэмжээг 17460 га газар болгож бууруулан аймгийн ИТХ-ын 2021 оны 03 дугаар тогтоолоор баталсан.</p> <p>Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, холбогдох судалгаа, тооцоо дүгнэлтийг боловсруулан тус Газрын даргын 2021 оны 09-р сарын 22-ны өдрийн 2/1804 тоот албан бичгээр БХБЯ-нд хүргүүлсэн.</p>
3		<p>2021.06.21 Агентлагын дарга нарт /Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх, төвийн цахим програм хангамжийг бүрэн ашиглах, иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг мэдээлэх,</p>	<p>Нийт 246 өргөдлөөс 1. Хүсэлт 170 / 69% 2. Гомдол 67 / 27 % / Газрын маргаантай асуудлыг шийдвэрлүүлэх тухай/ 3. Санал 9 / 3.6%</p> <p>“Газрын нэгдмэл сангийн удирдлагын цогц систем” программ хангамжийг нэвтрүүлж хүнд суртал, шат дамжлагыг багасгах, газрын маргаантай холбоотой зөрчлийг арилгах, мэдээллийг ил тод нээлттэй болгох нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.</p>
4		<p>2021.06.01</p>	<p>“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны баримт бичгийн 2021 оны хэрэгжилтийн явцын тайланг гарган Барилга, хот байгуулалтын яаманд цахим</p>



		<p>Салбарын дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах</p>	<p>шуудангаар, Үндэсний хөгжлийн газарт 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 3/1771 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар тушаалаар Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг болон “Бүсийн хөгжлийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийн төсөл боловсруулах дэд ажлын хэсгийн боловсруулж буй “Бүсчилсэн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-т тусгах саналаа 2021 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 2/1690 тоот албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Салбарын дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг ханган тухай бүрд нь тайлагнан ажиллаж байна.</p> <p>Мөн БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын дагуу Салбарын дунд хугацааны зорилтот хөтөлбөрт тусгуулах “Оролцогчийн шинжилгээ”-г гарган БХБЯ-нд хүргүүлсэн.</p>
5		<p>2021.04.14 №24 Монгол улсын Газрын нэгдмэл сангийн 2020 оны тайлангийн талаар</p>	<p>Тус хурлын тэмдэглэлд тусгагдсаны дагуу “Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийг төрийн үйлчилгээний нэгдсэн портал /e-mongolia/-тай холбох, сервис үйлчилгээ гаргах ажлыг гүйцэтгэх” АД/2021-26 дугаар бүхий ажлын даалгаврыг 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр ГЗБГЗЗГ-ын дарга баталсан. Тус ажлын даалгаварт тусгагдсан 14 төрлийн сервис үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia/-тай холбох ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс тус оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хооронд гүйцэтгүүлэхээр “Софт мастер” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулж гэрээний иж бүрдэлд тусгасан ажлыг гүйцэтгүүлсэн. Тус ажлын хүрээнд 15 төрлийн сервис үйлчилгээг бэлтгэн Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /e-mongolia/-д хүргүүлсэн. Газрын төлбөр, татвар, Улсын тэмдэгтийн хураамжийг төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia/, төлбөрийн цахим систем Ebarimt-аар төлөх боломжийг бүрдүүлсэн. Мөн Үйлчилгээний хураамжийг Ebarimt цахим төлбөрийн системээр төлөх хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв нь уг үйлчилгээг хэрэглээнд нэвтрүүлэх зөвшөөрөл хүлээгдэж байна.</p> <p>Газрын нэгдмэл сангийн 2020 оны “Газарт учирсан хохирол”-ын ГТ6 тайлан, “Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ”-ний ГТ7 тайланг 21 аймаг, нийслэлээс хүлээн авч, улсын хэмжээнд нэгтгэсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. 2020 онд улсын хэмжээнд нийт 5'559'192.9 га газарт хохирол учирсан байгаа бөгөөд өмнөх оны дүнгээс 2'256'521.2 га талбайгаар бага байна. Үүнийг ангилан үзвэл тариалангийн 86'622.2 га, бэлчээр ба бусад өвслөг ургамал газрын 5'255'560.7 га, хот тосгон, бусад суурин газрын 44'178.0 га, ойн сан бүхий газрын 136'588.9 га, усны сан бүхий газрын 151.0 га газарт тус тус хохирол учирсан бол 36'092.0 га газар ухагдаж эвдэрсэн байна.</li> <li>2. 2020 онд улсын хэмжээнд нийт 4'089'216.7 га газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг авсан бөгөөд өмнө оны дүнгээс 843'890.5 га талбайгаар их</li> </ol>

			байна. Үүнийг дотор нь ангилан үзвэл тариалангийн 228'981.7 га, бэлчээр ба бусад өвслөг ургамал газрын 3'785'850.7 га, хот тосгон, бусад суурин газрын 29'595.0 га, ойн сан бүхий газрын 28'012.6 га, усны сан бүхий газрын 426.7 га газарт хамгаалах арга хэмжээг авсан бол 16'349.0 га газрыг уурхайн эдэлбэр газарт нөхөн сэргээх арга хэмжээг авсан байна.
6	2021.03.31 №21 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаар		Тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хугацаанд холбогдох байгууллагуудад тайлагнан ажиллаж байна.
7	2021.03.24 №19 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай		2021 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ манай байгууллагад байхгүй бөгөөд урсгал төсвөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг 2021 оны 04 дүгээр сард багтаан тендер зарлаж дууссан болно.
8	2021.09.15 №51 Төсвийн хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх, гүйцэтгэлд хяналт шалгалт хийх, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллах		Тус журмын дагуу 2022 оны Төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөллийг боловсруулан БХБЯ болон Сангийн яаманд хүргүүллээ. Мөн Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгох, хяналт тавих, тайлагнахад үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.
9	2021.09.15 №51 БОАЖЯ, Газрын газрын харилцааны салбарын мэдээллийн сан, улсын тусгай хэрэгцээнд авсан газрын мэдээллийг "Орон зайн мэдээллийн сан"-д оруулах, олон нийтэд нээлттэй болгох		Газрын шинэтгэлийн үндэсний хорооны 2021 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах арга хэмжээний төлөвлөгөөнд туссан Үндэсний орон зайн өгөгдлийн геопорталыг хөгжүүлж, үйл ажиллагаанд оруулах ажлын хүрээнд орон зайн өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэгч, ашиглагч, түгээгч байгууллагуудын мэдээллийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн С/36 тушаалаар батлуулсан суурь орон зайн 18 дэд сан бүрт зориулан өгөгдлийн үзүүлэлтийн /UML/ стандартын дагуу хөрвүүлэн дээрх геопорталд оруулах ажлын хийж гүйцэтгээд байна. Үүнд, БОАЖЯ-ны мэдээллүүд болох тусгай хамгаалалтад авсан газрын мэдээлэл “Газар ашиглалт” төрөлд хамаарч нэгдсэн мэдээллийн санд орсон болно. Ингэснээр тус байгууллагын мэдээллийн сан нь газрын харилцааны мэдээллийн сантай нэгтгэгдэн геопорталаар дамжин иргэд олон нийтэд нээлттэй болсон. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем геопорталаар дамжуулан Улсын тусгай хэрэгцээний газруудын хил заагийн мэдээллүүд болох Улсын тусгай хамгаалалттай газар, Улсын хилийн зурвас, Аймаг дундын отрын бэлчээр, Чөлөөт бүсийн газар, Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай, Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар зэрэг мэдээллийг тус тус олон нийтэд нээлттэй болгосон.
10	2021.09.29 №53 “Агентлагын дарга нарт”		Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, Барилга, хот байгуулалтын сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон бусад байгууллагаас өссөн дүнгээр 2021 оны

			<p>байдлаар 72 тогтоол шийдвэрийг хүлээн авч, газрын “Үүрэг даалгаврын цахим систем”-д бүртгэн, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.</p> <p><b><u>Хяналтад авсан:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Ерөнхийлөгчийн зарлиг – 2</li> <li>• Засгийн газрын тогтоол – 23</li> <li>• Засгийн газрын хуралдааны тэмдэглэл – 15</li> <li>• Ерөнхий сайдын захирамж – 3</li> <li>• Шадар сайдын шийдвэр – 1</li> <li>• Засгийн газрын хэрэг эрх газрын шийдвэр – 2</li> <li>• Төрийн албаны зөвлөлийн шийдвэр 2</li> <li>• БХБСайдын тушаал - 6</li> <li>• БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэр - 2</li> <li>• БХБСайд, Сангийн сайдын хамтарсан тушаал – 1</li> <li>• Бусад яам, агентлагын даргын шийдвэр 16</li> </ul> <p>Үүнээс “Ажлын хэсэг байгуулах тухай”</p> <ul style="list-style-type: none"> <li>• <b><u>Газрын даргатай</u></b> холбогдуулан гаргасан:</li> <li>• Ерөнхийлөгчийн зарлиг 1,</li> <li>• Ерөнхий сайдын Захирамж – 3,</li> <li>• <b><u>Орлогч даргатай</u></b> холбогдуулан гаргасан:</li> <li>• БХБСайдын тушаал -1,</li> <li>• <b><u>Нэгжийн дарга</u></b> нартай холбогдуулан гаргасан:</li> <li>• Батлан хамгаалахын сайдын тушаал -1 бүртгэлтэй байна</li> </ul> <p>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу тус тус үнэлж, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээ авч, шийдвэрлэж ажилласан.</p>
11		2021.10.27 “Агентлагын дарга нарт”	<p>Байгууллагын албан хаагчдыг Вакцины 3 дугаар тунд идэвхитэй хамрагдахыг 10-11-р сард уриалж, БХБЯ-тай хамтран явуулын вакцинжуулалтын багийг ажлын байран дээр авчирч 26 албан хаагчийг вакцинжуулалтад хамруулсан. 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 89 албан хаагчаас 56 албан хаагч Вакцины 3 дугаар тунд хамрагдаад байна.</p> <p>Ковид 19 цар тахлаас урьдчилсан сэргийлэх, халдвар хамгаалалтын дэглэмийн мөрдөж ажиллах, албан өрөө тасалгаанд тогтмол агаар сэлгэлт хийж, ариутгаж ажиллахыг албан хаагчдад мэдээлж ажиллаж байна. Мөн байгууллага дээрх Ковид-19 цар тахлын цаг үеийн мэдээг БХБЯ-ны шуурхай штабт өдөр бүр мэдээллж байна.</p>
<b>Барилга, хот байгуулалтын сайдын тушаал</b>			
1		2021.07.19 №160 Ажлын хэсэг байгуулах тухай	<p>Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 38-р тэмдэглэлээр үүрэг өгөгдсөний дагуу Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 160 дугаар тушаал, Төв аймгийн Засаг даргын 2021 оны 07</p>

дугаар сарын 09-ний өдрийн А/422 тоот захирамжаар тус тус ажлын хэсэг байгуулагдан бэлтгэл ажлыг ханган ажилласан.

Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 160 дугаар тушаалаар Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн сумдын нутаг дэвсгэрт шинэ дагуул хотыг хөгжүүлэх, үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор газрыг улсын тусгай хэрэгцээнд авах хэмжээ, заагийг тогтоох судалгаа хийх, санал, дүгнэлт боловсруулах, шаардлагатай газар чөлөөлөх ажлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажилласан.

Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт тусгай хэрэгцээнд авахаар төлөвлөж буй **19390.4** га газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж, өмчилж байгаа нийт **2983** нэгж талбарын **7603.7** га газар давхцаж байна. Давхцалтай **2983** нэгж талбараас газар дээрээ үйл ажиллагаа явуулж байгаа болон үл хөдлөх хөрөнгөтэй **183** нэгж талбарт Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 202/196 дугаар хамтарсан тушаалаар баталсан аргачлал, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 203 дугаар тушаалын дагуу мэргэжлийн байгууллагаар урьдчилсан үнэлгээ хийлгэхэд 40.532.510.036 төгрөгийн нөхөх олговрын тооцоо гарсан.

Тусгай хэрэгцээнд авах талбайтай давхцаж нөлөөлөлд өртсөн газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч иргэн, хуулийн этгээдэд Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагааны мэдэгдлийг 2021 оны 07 дугаар сарын 29-ний өдөр хийж, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраар уламжлан зохион байгуулсан.

Төв аймгийн Алтанбулаг сумын иргэдтэй 2021 оны 08 сарын 17-ны өдөр, Сэргэлэн сумын иргэдтэй 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдөр, 2-р багийн иргэдтэй 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдөр тус тус уулзалт хийж газрыг улсын тусгай хэрэгцээнд авах талаар танилцуулга мэдээлэл хийх, саналыг сонсох үйл ажиллагааг ажлын хэсгийн зүгээс зохион байгуулсан.

Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт 19390.4 га газрыг Улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 06 дугаар хуралдаанаар хэлэлцэж, газрын хэмжээг 17460 га газар болгож ИТХ-ын 03 дугаар тогтоолоор албажуулж ирүүлсэн болно.

Засгийн газрын 2021 оны 307 дугаар тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрийн 19390.4 га газрыг үндэсний хэмжээний бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан. Газрыг газрын кадастрын улсын мэдээллийн санд бүртгэж, газар ашиглуулах асуудлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт даалгасны дагуу газрын кадастрын нэгдсэн мэдээллийн санд бүртгэсэн.

			<p>Хөшигийн хөндий орчмын нэгдсэн төлөвлөлтийн байр зүйн зураг зохиох /1:5000-ны масштабтай/ ажлын даалгаврыг боловсруулж, БХБЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Хөшигийн хөндийн олон улсын нисэх онгоцны буудлыг даган хөгжүүлэх бүс нутаг болон “Шинэ хот /Шинэ Зуунмод/” байгуулахаар төлөвлөсөн 25000 га газарт “Геомастер” ХХК 1:5000-ны масштабтай байр зүйн зураглал гүйцэтгэсэн.</p> <p>Зураглалын ажлын хүрээнд Хөшигийн хөндий орчмын газрын гадаргын өндрийн тоон загвар боловсруулан, газрын кадастрын мэдээллийн систем дэх нэгж талбарын тодруулалтыг хийж гүйцэтгэсэн. Тоон зураглалыг суурин болон хээрийн хэмжилтээр хяналт хийж, тус газрын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 2021/20 дүгнэлтээр ГЗБГЗЗГ-ын архив, мэдээллийн төвд хүлээн авсан.</p>
2		2021.03.03 №44 Журмын хэрэгжилтийг хангах тухай	<p>21 аймаг, нийслэлд дуудлага худалдааны орлогын тусгай дансыг нээж дуудлага худалдааны орлого, дэнчинг төвлөрүүлж байна. Аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 1617 газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа зохион байгуулагдсанаас газрын биржийн цахим системээр 1488, танхимаар 129 дуудлага худалдаа журмын дагуу зохион байгуулагдсан. 2021 онд зохион байгуулагдах дуудлага худалдааны орлогын төлөвлөгөөний төсөөлөл, дуудлага худалдааны орлогоос зарцуулах арга хэмжээний төлөвлөгөөний саналыг 21 аймаг, нийслэлээс 1/871 тоот албан бичгийн дагуу саналыг авч нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн.</p>
3		2019.03.26 №53 Журам батлах тухай	<p>Барилга, хот байгуулалтын салбарын тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг Нэгдсэн мэдээллийн цахим бүртгэлийн системээр дамжуулан эрхлэхэд нийцүүлэн “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгох, хяналт тавих журам”-ийн төслийг шинэчлэн өөрчилсөн төслийг боловсруулсан. Барилга, хот байгуулалтын Сайдын 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 245 дугаар тушаалаар “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг аж ахуйн нэгж, байгууллагад олгох, түүнд хяналт тавих журам” шинэчлэгдэн батлагдаж тус журмын дагуу 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 2/2259 тоот цахим мэдээллийн системд нэвтрэх эрх, үндсэн хэрэглэгчийн дүрийг тодорхойлон албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлж системд нэвтрэх үндсэн мэргэжилтний эрхийг авсан.</p> <p>Барилгын нэгдсэн мэдээллийн <a href="http://www.license.mcis.gov">www.license.mcis.gov</a> цахим системд “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах” эрх сунгуулахаар 2 аж ахуйн нэгж хүсэлт ирүүлснийг хүлээн авч журмын дагуу хянаж инженерийн техникийн ажилтны бүрдэл дутуу байгаа шалтгаанаар буцаагдсан.</p>
4		2019.03.26 №54 Журам батлах тухай	<p>Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх, экспертиг сонгон шалгаруулах үйл ажиллагаа Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 22 дугаар тушаалаар батлагдсан “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-өөр шилжүүлэн ирүүлсэнтэй холбогдуулан “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-т бүртгэлтэй Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертийн эрх авсан зөвлөхүүдийг газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн А/156 дугаар тушаалаар</p>

		<p>архитектур, орон зайн 20, нийгэм эдийн засгийн 4, геодези, өндөржилт, улаан шугамын 4, газар зохион байгуулалтын 3 нийт 31 экспертүүдийг томилсон.</p> <p>Журмын 3.1, 3.2 дэх хэсэгт заасны дагуу экспертийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Барилга, хот байгуулалтын яам, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ, ШУТИС-ийн Барилга, Архитектурын сургууль, “Монголын Архитекторуудын Эвлэл” ТББ-ийн төлөөллийг оролцуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн А/157 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан.</p> <p>Барилга, хот байгуулалтын салбарын нэгдсэн бүртгэл хөтлөх, цахимжуулах бодлогын хүрээнд барилга, байгууламжийн зураг төсөлд магадлал, хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх үйл ажиллагааг цахим системээр дамжуулан зохион байгуулж, бүртгэл хийхээр зорилт тавин ажиллаж байгаатай холбогдуулан “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх экспертиз хийх дүрэм”-ийг шинэчлэн боловсруулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын дэргэдэх “Зөвлөл”-ийн хурлаар 2021 оны 12 дугаар сарын 02-нд хэлэлцүүлэн 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 1/2404 тоот албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.</p>
--	--	---